

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/138/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

Аудитын үнэмлэх № 1302/116
танай _____ -ны № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН 6-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ДУЛАМСҮРЭН-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013023017

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,647.0	29,530.7
2	Авлага	0.0	0.0
8	Ажиллагсадтай холбогдсон авлага	0.0	574.9
60	БАРАА МАТЕРИАЛ	1,168.4	2,035.8
61	Түүхий эд материал	0.0	0.0
63	Эм боох материал	1,168.4	2,035.8
66	Хангамжийн материал	16,478.5	26,920.0
67	Бичиг хэргийн материал	139.4	972.5
68	Аж ахуйн материал	0.0	0.0
70	Түлш шатах тослох материал	1,085.0	4,817.5
71	Барилгын засварын материал	0.0	137.5
72	Хүнсний материал	1,276.3	2,800.9
73	Бусад хангамжийн материал	13,977.8	18,191.6
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	518,531.3	507,999.0
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	518,531.3	507,999.0
108	Биет хөрөнгө	508,721.3	498,739.0
109	Барилга байгууламж	480,000.0	480,000.0
110	Хуримтлагдсан элэгдэл		-13,333.3
113	Машин, тоног төхөөрөмж	22,904.9	33,586.7
114	Хуримтлагдсан элэгдэл	-1,973.4	-8,306.6
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,789.8	7,789.8
116	Хуримтлагдсан элэгдэл		-997.6
126	Биет бус хөрөнгө	9,810.0	9,260.0
127	Програм хангамж	1,650.0	1,650.0
128	Хасагдуулга		-550.0
129	Бусад биет бус хөрөнгө	8,160.0	8,160.0
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	536,178.3	537,529.7
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	6.7	6.7
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6.7	6.7
164	Өглөг	0.0	
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	6.7	6.7
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	536,171.6	537,522.9
215	Засгийн газрын хувь оролцоо	536,171.6	537,522.9
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	8,160.0	8,160.0
217	Өмч: -Төрийн өмч	8,160.0	8,160.0
223	Хуримтлагдсан үр дүн	528,011.6	529,362.9
224	Өмнөх үеийн үр дүн	528,011.6	528,011.6
225	Тайлант үеийн үр дүн	0.0	1,351.4
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	536,178.3	537,529.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	723,929.1	230,882.5
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	708,415.2	213,734.3
77	Нийтлэг татварын бус орлого	519,152.4	1,359.8
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	519,152.4	1,359.8
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	519,152.4	1,359.8
102	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	189,262.8	212,374.5
103	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	189,262.8	212,374.5
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,513.9	17,148.2
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,513.9	17,148.2
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,513.9	17,148.2
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	195,917.6	229,531.1
148	УРСГАЛ ЗАРДАЛ	195,917.6	229,531.1
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,696.5	219,668.0
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	83,739.4	150,304.3
151	Цалин	65,822.5	90,135.1
152	Нэмэгдэл цалин	13,504.2	47,368.8
153	Унаа хоолны хөнгөлөлт		
154	Урамшуулал	4,412.7	12,800.4
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,463.5	19,543.6
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,885.4	13,538.3
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	896.3	1,503.0
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	702.7	1,202.4
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	183.8	293.8
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,795.4	3,006.1
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,104.4	11,415.7
165	Гэрэл цахилгааны зардал	2,605.4	3,218.2
166	Түлш, халаалтын зардал	7,719.0	7,477.5
167	Цэвэр, бохир усны зардал	780.0	720.0
168	Байрны түрээс	0.0	0.0
170	Хангамж, бараа материалын зардал	1,834.6	1,875.1
171	Бичиг хэргийн материал	669.4	653.5
172	Тээвэр, шатахууны зардал	303.0	367.6
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	700.0	675.0
174	Ном, хэвлэлийн зардал	51.8	
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	110.4	179.0
181	Нормативт зардал	11,034.2	11,069.9
182	Эм	1,372.6	2,686.4
183	Хоол	9,645.1	8,113.5
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16.6	270.0
185	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	1,862.5
189	Урсгал засвар	0.0	1,862.5
190	Томилолт зочны зардал	250.0	774.9
191	Дотоод албан томилолт	250.0	774.9

194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	150.0	396.0
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	0.0	243.0
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	150.0	153.0
209	Бараа үйлчилгээний бусад зардал	3,120.4	22,426.0
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,147.0	1,211.8
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,973.4	21,214.2
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,221.0	9,863.1
228	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70,896.5	9,863.1
235	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,896.5	9,863.1
247	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,324.5	
250	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,324.5	
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	528,011.6	1,351.4
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	528,011.6	1,351.4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.0	0.0	0.0	0.0
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.0	0.0	0.0	0.0
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.0	0.0	528011.6	528011.6
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8160.0	0.0	528011.6	536171.6
10	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8160.0	0.0	528011.6	536171.6
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8160.0	0.0	528011.6	536171.6
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0

15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0.0	0.0	0.0	0.0
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0	0.0	0.0
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.0	0.0	1351.4	1351.4
18	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8160.0	0.0	529362.9	537522.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	204776.7	229522.7
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189262.8	212374.5
78	Нийтлэг татварын бус орлого		
92	Бусад орлого		
103	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	189262.8	212374.5
104	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	189262.8	212374.5
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15513.9	17148.2
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15513.9	17148.2
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15513.9	17148.2
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	203126.7	218840.9
148	УРСГАЛ ЗАРДАЛ	203126.7	218840.9
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128905.7	208977.8
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	83440.3	149894.9
151	Үндсэн цалин	65523.9	98404.6
152	Нэмэгдэл	13504.2	38690.0
153	Унаа хоолны хөнгөлөлт		
154	Үр дүнгийн урамшуулал	4412.2	12800.4
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	10755.9	20527.9
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	7177.7	14893.2
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	896.3	1408.5
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	702.7	1126.8
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	183.8	252.3
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1795.4	2817.1
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	12189.4	15148.2
165	Гэрэл цахилгааны зардал	2605.4	3218.2
166	Түлш, халаалтын зардал	8804.8	11210.0
167	Цэвэр, бохир усны зардал	780.0	720.0
168	Байрны түрээс		
170	Хангамж, бараа материалын зардал	4783.5	3603.5
171	Бичиг хэрэг	808.8	700.9
172	Тээвэр, шатахуун	303.0	367.6
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	700.0	675.0
174	Ном	51.8	
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2919.9	1860.0
181	Нормативт зардал	15979.0	14348.7
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2541.0	2541.0

183	Хоол, хүнс	10921.4	9291.0
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2516.6	2516.6
185	Эд хогшил , урсгал засварын зардал		2000.0
186	Урсгал засвар		2000.0
187	Томилолт, зочны зардал	250.0	774.9
188	Дотоод албан томилолт	250.0	774.9
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150.0	396.0
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		243.0
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.0	153.0
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1357.6	2283.7
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1357.6	2283.7
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74221.0	9863.1
225	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70896.5	9863.1
232	Төвлөрүүлэх шилжүүлэг	70896.5	9863.1
244	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3324.5	
247	Төвлөрүүлэх шилжүүлэг	3324.5	
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1650.0	10681.8
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1650.0	10681.8
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1650.0	10681.8
263	Дотоод эх үүсвэрээр	1650.0	10681.8
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1650.0	10681.8
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1650.0	-10681.8
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0	(0.0)
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,250.0	219,659.6	4,590.4
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	224,250.0	219,659.6	4,590.4
4	Бараа, үйлчилгээний зардал	224,250.0	219,659.6	4,590.4
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,057.6	149,894.9	1,162.7
6	Үндсэн цалин	103,358.4	98,404.6	4,953.8
7	Нэмэгдэл	36,364.6	38,690.0	(2,325.4)

8	Унаа, болон бусад нөхөн олговор	500.0	0.0	500.0
9	Урамшуулал	10,834.6	12,800.4	(1,965.8)
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,527.9	20,527.9	0.0
12	Тэтгэврийн даатгал	14,445.5	14,893.2	(447.7)
13	Тэтгэмжийн даатгал	1,520.0	1,408.5	111.5
14	ҮОМШӨ ний даатгал	1,216.5	1,126.8	89.7
15	Ажилгүйдлийн даатгал	304.1	282.3	21.8
16	Эрүүл мэндийн даатгал	3,041.2	2,817.1	224.1
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,575.4	15,148.2	3,427.2
18	Гэрэл цахилгаан	2,605.4	3,218.2	(612.8)
19	Түлш, халаалт	13,570.0	11,210.0	2,360.0
20	Цэвэр, бохир ус	2,400.0	720.0	1,680.0
21	Байрны түрээс			0.0
22	Хангамж, бараа материалын зардал	4,663.4	4,663.4	0.0
23	Бичиг хэрэг	688.8	700.9	(12.1)
24	Тээвэр (шатахуун)	303.0	367.6	(64.6)
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	700.0	675.0	25.0
26	Ном, хэвлэл	51.7		51.7
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,919.9	2,919.9	0.0
30	Нормативт зардал	14,349.2	14,348.6	0.6
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,541.0	2,541.0	0.0
32	Хоол, хүнс	9,291.6	9,291.0	0.6
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	2,516.6	2,516.6	0.0
34	Эд хогшил худалдан авах	2,000.0	2,000.0	0.0
35	Урсгал засвар	2,000.0	2,000.0	0.0
39	Томилолт, зочны зардал	774.9	774.9	0.0
41	Дотоод албан томилолт	774.9	774.9	0.0
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,459.0	1,459.0	0.0
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		243.0	(243.0)
46	Мэдээллийн технологийн зардал	1,459.0	1,216.0	243.0
53	Бараа үйлчилгээний бусад зардал	10,842.6	10,842.6	0.0
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,842.6	10,842.6	0.0
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,250.0	224,250.0	0.0
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	203,674.6	203,674.6	0.0
99	Улсын төсвөөс санхүүжих	203,674.6	203,674.6	0.0
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,575.4	20,575.4	0.0
104	Орон нутгийн төсвөөс	20,575.4	20,575.4	0.0

120	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0		0.0
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0		0.0
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.0)
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.0)
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	0.0
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0
131	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэг нь Хүүхэд нэг бүрийг амьдралд хэрэгтэй чадварыг хөгжүүлсэн эрүүл аюулгүй амьд орчинг бүрдүүлэн, түүнийг өөрөө сонгон тоглонгоо суралцах зарчмаар сонгон орчноосоо мэдлэгээ бүтээсэн ухаалаг, хамтач, цэгцтэй, уйгагүй оролдлоготой, бүтээлч, эрүүл чийрэг, баяр баясгалантай иргэн төлөвших суурийг тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 315.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		574.9	574.9
Бараа материал	17647	28955.8	11308.8
Үндсэн хөрөнгө	518531.3	507999	-10532.3
Нийт хөрөнгө	536178.3	537529.7	1351.4
Өр төлбөр	6.7	6.7	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	536171.6	537522.9	1351.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	536178.3	537529.7	1351.4

Бараа материалын дансны үлдэгдэл 11,308.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой. Авлага дансны үлдэгдэл 574.9 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын илүү төлөлттэй холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,532.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1351.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 224,250 мянган төгрөгөөр, 219659.6 мянган төгрөгөөр нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 17148.2 мянган төгрөгийн, улсын төсвөөс 212374.5 мянган төгрөгийн төгрөгийг авч нийт 229,522.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 219,659.6 мянган төгрөгийг зарцуулж 9,863.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэлээс хянахад цалингийн зардлаас 1,172.6 мянган төгрөгийг, хоолны зардлаас 8,690.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн дүнтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилт аваагүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын дагуу бэлтгэсэн, анхан шатны бүртгэл хөтлөлт сайн байсан. Харин Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43-р тогтоолыг зөрчиж багш нарт биеийн тамирын хувцас 500.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн зөрчил илэрлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулхаас 15 мэдээлэл хугацаа хожимдуулж 132 мэдээллийг бүрэн бүрэн гүйцэд оруулсан. Хоцорсон 15 мэдээлэл нь зарим саруудын гэрээ, тушаал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нөхөн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- ❖ Тус цэцэрлэг нь 100 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2021 оны төсөвт үндсэн багш 2, туслах багш 2 батлагдсан бөгөөд одоогийн байдлаар 3 анги хичээллэж, үндсэн болон туслах 2 багш батлагдсан орон тооноос илүү ажиллаж байна. Орон тооны талаар аймгийн Боловсрол соёлын газар болон холбогдох мэргэжилтнүүдэд уламжлахад 2022 оны төсөвт дутуу орон тоог суулгасан гэсэн тайлбар өгсөн Тиймээс цэцэрлэгийн үндсэн, туслах багш нарын орон тооны асуудлыг шийдвэрлүүлж, бүрэн хүчин чадлаар нь үйл ажиллагааг жигд явуулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолыг зөрчиж багш нарт 500.0 мянган төгрөгөөр биеийн тамирын хувцас худалдан авч өгсөн зөрчил илэрлээ.

4.1 Залруулсан алдаа: байхгүй

4.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолыг зөрчин, багш нарт биеийн тамирын хувцас 500.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага : БСГ-т 18982.9 мянган төгрөгийн орон тоог шийдвэрлэх талаар албан шаардлага хүргүүлээ.

2021 оны батлагдсан орон тооноос бага ангийн үндсэн, туслах багшийн 2 орон тоог илүү ажиллуулж цалин, НДШ-ийн зардлыг 18982984 төгрөгийг цалингийн сан илүү батлагдсанд багтаан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 23 дугаар зүйлийн 23.1 “Төрийн аудитын байгууллагын хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.2.1.-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө”4.2.1.5 “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн”, гэсэн заалтуудыг үндэслэн

1. Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооноос илүү ажиллаж байгаа 2 орон тоог холбогдох газруудад уламжилан шийдвэрлүүлж цалин, НДШ-ийн зардлыг батлуулан ажиллах, бодитой шийдвэрт хүрэхгүй тохиолдолд цаашид ажиллуулах байдлыг таслан зогсоох.
2. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны дотор гарган Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт ирүүлэхийг Аймгийн Боловсрол соёлын газрын дарга Д.Бямбацогт, төсвийн мэргэжилтэн Р.Алтантуяа нарт даалгав.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ Си-Ти-Эс ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг бүртгэлд тусгасан боловч зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүнг гаргаагүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Си-Ти-Эс ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс ашиглаж эхлэх, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг уг программаар гаргах;
- ✓ Дутагдалтай орон тооны асуудлыг аймгийн Боловсрол соёлын газар, холбогдох буюу мэргэжилтнүүдэд уламжлан шийдвэрлүүлэх, цэцэрлэгийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Тосонцэнгэл сумын 6-р цэцэрлэг	2	19,4			1	0.5	1	18,9		

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Огноо: 2022/02/22

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

Г.ЗАЯА

Огноо: 2021/02/22

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2021/02/22